



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

УИХ-ын саналын дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар,
хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл
ажиллагааны үр дүн

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Хоёрдугаар газар

Газрын захирал: О.Мэндбаяр

Аудитын менежер: Х.Баярмаа

Аудитор: Ц.Сугармаа
З.Цээнээ

Шинжээч: Л.Эрдэнэчулуун
Ш.Отгонбаяр
Д.Болормаа

Хянасан: Х.Баярмаа

2007 оны 11 дүгээр сар

Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.
www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
210642 Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	4
Товчилсон үгийн тайлбар	5

Бүлэг 1

ХХҮГ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт, мэдээллийн үр нөлөөтэй тогтолцоо үйлчлэхгүй байна

Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд зарим чиг үүргийг тусгаагүй байна	6
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар өөрийн чиг үүрэгт хамааралгүй үйлчилгээ үзүүлсэн байна.....	7
Үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох шаардлагатай.....	7
Хамтын ажиллагаанд суурилсан үр ашигтай дэд бүтэц бий болоогүй байна	9
ХХҮГ-ын үйл ажиллагаанд дотоод хяналтын тогтолцоо үйлчлэхгүй байна	9
Нөөцийг үр ашиггүй зарцуулсан байна	10
Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт, тайлагналд тавих хяналт сул байна	12
ТДОИХС-гийн харилцах дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдэж байгаа боловч тайлан тэнцэл гаргадаггүй, НХХЯ-нд өссөн дүнгээр гаргасан мэдээгээр тайлагнаж байна	13
Мэдээллийн баазын бүрдүүлэлт, түүний ашиглалт хангалтгүй байна	15

Бүлэг 2

Тогтвортой ажлын байр бий болж, ажилгүйчүүдийн тоо буурсан гэх бодитой үзүүлэлт алга байна

Ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулийн дагуу шийдвэрлэж байх шаардлагатай	16
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг үр нөлөөтэй зарцуулах боломж байна	18
Зээлийн эх үүсвэрийн хэмжээ нэмэгдсэн ч түүний ашиглалт хангалтгүй, ажлын байрны мэдээллийн сан бүрдээгүй байна	19
Мэргэжлийн сургалт олгох үйл ажиллагаанд тавих хяналт орхигджээ.....	21
Үйлчилгээ, арга хэмжээний зардлын гүйцэтгэлд хяналт тавихгүй байна.....	21
ХЗЗ-ийн эрэлт, хэрэгцээг судалж байгаа боловч нийт эрэлт, нийлүүлэлтийн харьцаа бүрэн илэрхийлэгдэхгүй байна	22

Зөвлөмж	24
----------------------	-----------

Холбогдох байгууллагын санал

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны санал Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн санал	26
---	----

Хавсралтууд:

Хавсралт-1.....	27
-----------------	----

Хавсралт-2.....	29
Хавсралт-3.....	30
Хавсралт-4.....	31
Хавсралт-5.....	32
Хавсралт-6.....	33
Хавсралт-7.....	34

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Улсын Их Хурлын санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн дагуу хийв.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлж байгаа эсэх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын тэнцвэрт байдлыг хангаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ болон арга хэмжээ үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэхэд аудит хийж холбогдох дүгнэлт, зөвлөмж боловсруулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, нийслэлийн зарим дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2006 он, 2007 оны эхний 9 сарын үйл ажиллагааг хэсэгчилсэн байдлаар хамруулав.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагааны болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайлан, мэдээг судлах,
- ХХҮГ-ын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээ, түүний хэрэгжилтийг судлах,
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтнүүдээс ярилцлага, асуулга лавлагаа авч, судалгаа, тоон мэдээлэлд суурилсан шинжилгээ хийх,
- ХХҮГ-т ХХҮХ-үүдээс ирүүлсэн мэдээ, нийгмийн халамжийн болон ХЭДС-гийн орлогын бүрдүүлэлт, түүний зарцуулалт хууль зүйн дагуу байгаа эсэхэд үйл ажиллагааны тайланд суурилсан шинжилгээ хийх,
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний үр дүнд Олон улсын байгууллагын дэмжлэгтэй төрийн бус болон хөндлөнгийн байгууллагын хийсэн үнэлгээ, тайлан, мэдээг судлах,
- Үндэсний статистикийн газраас гаргасан статистик мэдээ, тоо баримтыг ашиглах,
- ХХҮГ болон ХЭДС-гийн үйл ажиллагаатай холбогдсон бусад баримт материалтай танилцах.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГ	Засгийн газар
СЯ	Сангийн яам
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
НХХС	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
СЭЗС	Санхүү, эдийн засгийн сайд
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХЭДТХ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭДҮ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ
ХЭДАХ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ
ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл
ХЭА	Хөдөлмөр эрхлэлтийн алба
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
АДОТБЗ	Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл
ЭХМК	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс
БИТ	Бизнес инкубаторын төв
НХА	Нийтийг хамарсан ажил
АОДАХ	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ
НДТБ	Нийгмийн даатгалын төв байгууллага
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
МТДИБҮХ	Монголын тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо
ТДОИХСТД	Тахир дутуу, одой иргэдийн хөгжлийн сангийн тусгай данс
ТББ	Төрийн бус байгууллага
АБТ	Ажлын байрны төлбөр
АХГГГАХМАТХ	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль

Бүлэг 1

ХХҮГ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт, мэдээллийн үр нөлөөтэй тогтолцоо үйлчлэхгүй байна

1.1. Улсын Их хурлын 2004 оны "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" 14 дүгээр тогтоол, Засгийн газрын 2004 оны "Агентлаг байгуулах тухай" 205 дугаар тогтоолд заасны дагуу НХХС-ын эрхлэх асуудлын хүрээнд ХХҮГ ажиллаж, хөдөлмөр, халамжийн үйлчилгээг 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг дэх ХХҮХ-үүд 320 гаруй орон тоогоор гүйцэтгэж байна.



Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд зарим чиг үүргийг тусгаагүй байна

1.2. Нийгмийн халамжийн үйлчилгээнд улсын төсвөөс нийт 73.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, давхардсан тоогоор 1.3 сая хүн 75.4 тэрбум төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, мөнгөн тусламжийн үйлчилгээг хүртжээ. ХЭДС-д 6.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд нийт 4.2 тэрбум төгрөг зарцуулагджээ.

1.3. Нийгмийн халамжийн болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд ХХҮГ 19 чиг үүргийг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Гэвч хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, халамж, асрамжийн үйлчилгээ явуулж буй төрийн болон ТББ-ыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг төлөвлөж, түүний чиг хандлагыг тодорхойлох чиг үүргүүд бүрэн хэрэгжихгүй байна.

1.4. ТБУСТ хуулийн 23.4 дүгээр зүйлд "... агентлаг өөрийн чиг үүргийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид бүтээгдэхүүн нийлүүлнэ" гэж заасан. ХХҮГ СЭЗС (хуучин нэрээр) болон НХХС-ын 2001 оны "Үйлчилгээний журам, хураамжийн хэмжээг батлах тухай" 112/339 дүгээр тушаалаар гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа боловч 2006, 2007 оны үр дүнгийн гэрээнд энэ тухай тусгаагүй байна.

ХХҮГ өөрийн чиг үүрэгт хамааралгүй үйлчилгээ үзүүлсэн байна

1.5. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8.1-д “Байгууллага нь гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахын өмнө хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний эрх олгосон байгууллагын зөвшөөрлийг урьдчилан авсан байна” гэж заасны дагуу ХХҮГ Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох ёстой. Гэтэл жуулчлалаар ирсэн гадаадын иргэдийн визийн ангиллыг солих зөвшөөрөл өгч, тодорхойлолт гаргаж байжээ.

Үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох шаардлагатай

1.6. Нийгмийн халамжийн үйлчилгээнд 2005 онд 41,2 тэрбум төгрөг зарцуулсан бол 2006 онд 75.4 тэрбум төгрөгт хүрч, 34.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт үйлчлүүлэгчийн тоо 2005 онд 963,1 мянган хүн байсан бол хуулийн шинэчлэлийн хүрээнд 2006 онд 1373,6 мянган хүн болж, 410,5 мянган хүнээр буюу 42,7 хувиар өсчээ. /Хавсралт-1, Хавсралт-1.1, Хавсралт-1.2/

1.7. “Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай” хууль 2006 онд батлагдан хэрэгжсэнээр үйлчлүүлэгчийн тоо 2004 оноос 3.6 дахин өсөж, үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх, үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох шаардлага ХХҮГ-т бий болжээ.

1.8. Ажлын ачааллын жигд биш хуваарилалт нь иргэдэд үзүүлэх үйлчилгээнд хүнд суртал, дарааллыг бий болгож байгаа тул нутаг дэвсгэрийн онцлог байдал, үйлчилгээнд хамрагдагсдын тоотой уялдуулан хэлтсүүдийн орон тоо, бүтцийг боловсронгуй болгох шаардлагатай байна. Тухайлбал:

Дүүргийн нэр	Үйлч/тоо	Орон Тоо	1 ажилтанд ногдох үйлч/ тоо
Сүхбаатар	53736	15	3582
Чингэлтэй	60807	17	3576
Баянзүрх	89850	17	5285
Хан-Уул	47307	14	3379
Сонгинохайрхан	97259	21	4631
Баянгол	67607	22	3073
Багахангай	3433	7	490
Налайх	21772	16	1360
Багануур	20504	8	2563

- БЗД-ийн ХХҮХ-ээр үйлчлүүлж буй иргэдийн тоо ЧД-ийн ХХҮХ-ээс 29043-аар олон байхад үйлчилгээг ижил 17 орон тоотойгоор гүйцэтгэж байна.
- СХД-ийн ХХҮХ, БГД-ийн ХХҮХ-ээс 29652-оор олон иргэдэд үйлчилгээ үзүүлж

байгаа боловч мөн ижил орон тоотойгоор ажил үйлчилгээг явуулж байна.

- Налайх болон Багануур дүүргийн ХХҮХ-т үйлчлүүлэгчдийн тоо бараг ижил буюу 1268 хүний зөрүүтэй байхад хэлтсүүдийн орон тоо хоорондоо 2 дахин зөрүүтэй байна.

1.9. 2006 оны халамжийн шинэчилсэн хуулийн нэг зорилт бол олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний шинэ хэлбэрийг нэвтрүүлж, удирдлагын төвлөрлийг сааруулах, үйлчилгээнд хамрагдах иргэдийг сонгох эрхийг орон нутагт шилжүүлэхэд чиглэгджээ.

1.10. Засаг захиргааны анхан шатны нэгж дээр "Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл"-ийг (АДОТБЗ) ажиллуулж эхэлсэн бөгөөд тус зөвлөлийн нарийн бичгийн дарга буюу сум, хороонд ажиллаж буй нийгмийн ажилтан анхан шатанд иргэдэд хүрч үйлчлэх үүргийг хүлээж, мэдээллийг түгээх, үйлчлүүлэгчийн бичиг баримтын бүрдлийг хангуулах, хэрэгцээг тогтоох, хүний гар дээр очиж буй хөрөнгийн зарцуулалтын эрх үүсгэх асуудлыг шууд хариуцах болжээ.

1.11. ХХҮГ болон ХХҮХ-ийн чиг үүргийн хүрээнд АДОТБЗ болон нийгмийн ажилтнуудтай хэрхэн харилцах талаар тодорхойгүй, ажлын явц, үр дүнг үнэлэх тогтолцоо үйлчлэхгүй байна.

1.12. Халамжийн тэтгэвэр авах эсэхийг Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс (ЭХМК) шийдвэрлэж байгаа ба ХХҮХ-үүдээс уг үйл ажиллагаанд оролцдоггүйгээс хяналтгүй олгогдож байна. 2007 оны эхний хагас жилийн байдлаар нийт 44.7 мянган хүнд, 7.0 тэрбум төгрөгийн тэтгэврийг уг комиссын шийдвэрээр олгожээ.

1.13. Шинэчилсэн хуулиар нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, мөнгөн тусламж олгож буй байдлын судалгааг үзүүлэв.
/Хавсралт-2/

1.14. "Хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай" хуулийн дагуу 2006 онд үзүүлбэл зохих үйлчилгээний явцад хөрөнгийн эх үүсвэргүйгээс 26280 гэр бүлд олгох 13,1 тэрбум төгрөгийн мөнгөн тусламж ондоо олгогдоогүй байна.

1.15. Дээрх хуулийн 5 дугаар зүйлийн 6.5-д заасны дагуу нэр бүхий 9 халамжийн төвд хүмүүжиж буй 135 хүүхдийн мөнгийг нэрийн данс нээлгүйгээр эцэг эх нь авчээ.

Түүнчлэн Цагдаагийн хэлтэст бүртгэлтэй орон гэргүй, орц траншейд амьдардаг, тэнэмэл зэрэг ямар нэгэн халамж, үйлчилгээнд хамрагдаагүй зохих тооны иргэд байсаар байна. Тухайлбал, нийслэлийн Чингэлтэй, Хан-Уул дүүргийн цагдаагийн хэлтэст 221 том хүн, 46 хүүхэд бүртгэгдсэн байна.

1.16. Иймд хуулийн заалтын дагуу асрамжийн төвд хүмүүжиж байгаа хүүхдүүдэд нэрийн данс нээж, насанд хүрэхээр нь тэдэнд олгож байх, халамжийн үйлчилгээнд хамрагдвал зохих иргэдийн судалгаа хийж, хамруулж байх нь зүйтэй.

1.17. Халамжийн үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоо жилээс жилд өсөж иржээ. 2006 оны 7 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн "Нийгмийн халамжийн тухай хууль" нийгмийн халамжийн байгууллагуудын тогтолцоо, үйлчилгээг шинэчлэх эхлэлийг тавьсан байна.



1.18. Хууль хэрэгжсэнээр халамжийн үйлчилгээний төрөл, хамрагдагсдын тоог бууруулж, улмаар иргэдэд зайлшгүй үзүүлэх халамжийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэх боломжтой болжээ. Гэвч шинэчилсэн хууль хэрэгжиж эхлээд жил хүрээгүй байхад НХХЯ-наас “Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл боловсруулан ЗГ-т оруулсан байна.


Хамтын ажиллагаанд суурилсан үр ашигтай дэд бүтэц бий болоогүй байна

1.19. Улсын хэмжээнд цөөнгүй тооны ТББ гишүүнчлэлийн хүрээнд болон нийгэмд үйлчлэх гэсэн зорилгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Гэвч ХХҮГ-аас үндсэн чиг үүргийн хүрээнд иргэд, ТББ, хувийн хэвшлийн оролцоог хэрхэн нэмэгдүүлэх, үйлчилгээний үр ашигтай дэд бүтцийг бий болгоход ямар хэлбэрээр хамтран ажиллах нь тодорхойгүй, зөвхөн зарим ТББ-уудад санхүүгийн дэмжлэг, хөрөнгө, бараа материал олгох төдийгөөр хязгаарлагдаж байна.

1.20. Харин хувийн хэвшлийн мэргэжлийн сургалтын байгууллага хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээгээр мэргэжил олгох болон давтан сургалтыг зохион байгуулахад түлхүү оролцож байна.

ХХҮГ-ын үйл ажиллагаанд дотоод хяналтын тогтолцоо үйлчлэхгүй байна

1.21. ХХҮГ-ын үйл ажиллагааны стратеги, бүтэц орон тоог НХХС-ын 2004 оны 160 дугаар тушаалаар баталжээ. ХХҮГ-ын бүтэц, орон тоог схемээр үзүүлбэл:



1.22. Нийгмийн халамжийн тухай хууль болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд 2005, 2006 онд орсон өөрчлөлтөөр аймаг, дүүргийн ХХҮХ-ийн даргыг тухайн шатны Засаг дарга томилдог болсон буюу удирдлагын босоо тогтолцооноос хэвтээ тогтолцоонд шилжсэн байна.

Ингэснээр ХХҮГ ХХҮХ-үүдийг шууд удирдах бус мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, салбарын дотоод хяналт тавих болж, чиг үүргийн томоохон өөрчлөлт орсон тул 2004 онд батлагдсан бүтцийг шинэчилж, өнөөгийн орон тоонд багтаан дотоод хяналтын нэгжийг бий болгох нь зүйтэй байна.

1.23. Өмнө хэрэгжиж байсан хуулиар халамжийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хяналтын алба, халамжийн улсын байцаагч хэрэгжүүлж байжээ. ХХҮГ-ын одоогийн бүтцээр Санхүү, хяналтын хэлтэст дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нэг, Тамгын хэлтэст үнэлгээ, мониторинг хариуцсан мэргэжилтэн нэг ажиллаж байгаа нь аймаг, дүүргүүдийн ХХҮХ, асрамжийн байгууллагуудад хяналт тавихад хангалтгүй юм.

1.24. ЗГ-ын 2006 оны 118 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн халамжийн сангийн дүрэм”-д сангийн хөрөнгийн хэмжээг тодорхойлох, хуваарилах, салбарын дотоод хяналт тавих үүргийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ гэжээ.

1.25. Гэвч ХХҮГ-аас төсвийн төлөвлөлт, зарцуулалт, НББ, халамжийн болон ХЭДС, ажлын байрны төлбөр, хураамжийн үйл ажиллагаа, аймаг, дүүргийн ХХҮХ-ийн төсөв, санхүү, халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудын үйл ажиллагаанд хяналт тавих үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

1.26. Аймаг, дүүргийн ХХҮХ-үүдийн төсөв санхүү, халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангуудын үйл ажиллагаанд дотоодын хяналт тавихгүй байна. Тухайлбал, БГД-ийн ХХҮХ-ийн 2006, 2007 оны зарим үйл ажиллагаанд хэсэгчилсэн байдлаар хийсэн аудитын явцад доорхи зөрчил, дутагдал илэрчээ. Үүнд:

- 2006 оны тайлан тэнцлээр гарсан бараа материалын орлого, зарлагын дүн, үлдэгдэл эд хариуцагчийн гаргасан тайлангийн дүнгээс зөрүүтэй,
- Бараа материалын үлдэгдэлд хэсэгчилсэн байдлаар тоолж үзэхэд 420,0 мянган төгрөгийн үнэ бүхий тэргэнцэр, сонсголын аппарат, таяг дутагдсан,
- Мэргэжлийн бус нягтлан бодогч ажиллуулснаар анхан шатны болон нягтлан бодох бүртгэл бүрэн хөтлөгдөөгүй, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооллого хийгээгүй, баримтын бүрдэлгүйгээр бэлэн мөнгө болон бараа материалыг зарлага болгосон,
- Байгууллага хоорондын авлага, өглөгийн туслах, журнал хөтлөөгүйгээс хоорондын тооцоо тодорхой бус болсон,
- Тайлан тэнцлийг ХХҮГ-аас аливаа хяналтын горимгүйгээр хүлээн авсан,
- Тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулаагүй.

Эдгээр нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 7, 8, 9,10, 11, 12 дугаар зүйлийн заалтууд зөрчигдсөн байна.

Нөөцийг үр ашиггүй зарцуулсан байна

1.27. 2006 онд улсын төсвөөс 68.6 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанаас 358,8 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. 209.5 сая төгрөгийн батлагдсан төсвөөс 205.7 сая төгрөгийг зарцуулжээ. **/Хавсралт-3/**

Эх үүсвэр	Үйлчлүүлсэн тоо	Дүн /мян.төг/
Урилга	11,958	62,179.7
Зөвшөөрөл олгох	12,504	127,540.8
Сунгалт	10,718	109,323.6
Үнэмлэх олгох	22,500	45,000.0
Тодорхойлолт	2,852	14,831.0
Бүгд	60,532	358,875.1

1.28. Сангийн сайдын 2005 оны 369 дүгээр тушаал, 2006 оны 3-56/249 дүгээр албан бичиг, НХХС-ын 2006 оны 1 дүгээр сарын 8 дугаар тушаалыг үндэслэн ХХҮГ-ын дарга Д.Баярсайхан 2006 оны 29 болон 31 дүгээр тушаал гаргажээ. Эдгээр тушаалаар ХХҮГ-ын 2005 оны үйл ажиллагааны орлогоос 60.0 сая төгрөгийг ажилтнуудад буцалтгүй тусламжид, 22,0 сая төгрөгийг нийгмийн асуудал шийдвэрлэхэд зориулан зарцуулжээ.

1.29. Түүнчлэн Сангийн сайдын 2007 оны 136 дугаар тушаал, НХХС-ын 2007 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 1/1043 дугаар албан бичиг, ХХҮГ-ын удирдлагын зөвлөлийн 2007 оны 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ХХҮГ-ын даргын 2007 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 67 дугаар тушаалаар төлөвлөгөөнөөс давсан орлогоос 176,0 сая төгрөгийг 2006 оны ажлын үр дүнгээр нэр бүхий хүмүүсийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулж олгосон байна.

1.30. Үүнд өмнөх онд буцалтгүй тусламж авч байсан ХХҮГ-ын нэр бүхий 15 хүнд бүгд 58,0 сая төгрөг, түүнчлэн тус байгууллагад ажилладаггүй хүмүүс болох НХХЯ-ны ахлах мэргэжилтэн Б.Алимаа, хуулийн зөвлөх Б.Алтанжаргал, мэргэжилтэн С.Үржинбадам, Д.Норжмаа, Б.Батсүх, Б.Пүрэвсүрэн, С.Наранцацрал нарт тус бүр 7.0 сая төгрөг, бүгд 49,0 сая төгрөг олгож, нийт 107,0 сая төгрөгийг буцалтгүй тусламж болон нийгмийн асуудалд зориулан олгожээ. **/Хавсралт-4/**

1.31. ХХҮГ-ын үйл ажиллагааны төсвийг үндэслэл муутай төлөвлөсөн болон Сангийн сайд, салбар хариуцсан сайд нарын шийдвэрүүд ийм боломж олгожээ.

1.32. Түүнчлэн гадаад, дотоод томилолтын тооцоонд хяналт тавилгүй, томилолтын зардлыг гүйцэтгэлээр биш төсөвлөснөөр зарлага болгож 1,891.3 мянган төгрөгийг, Төрийн албаны тухай хуульд тусгагдаагүй зардлаар 950.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

1.33. “Үйлчилгээний журам, хураамжийн хэмжээг батлах тухай” СЭЗС (хуучин нэрээр), НХХС-ын 2001 оны 112/339 дугаар тушаалаар баталсан журмын дагуу гадаадын ажиллах хүчинд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний хураамжаас орлогыг бүрдүүлж, төвлөрсөн дүнг Хөдөлмөр эрхлэлтийн газрын тухайн жилд батлагдсан улсын төсвийн санхүүжилтэд тооцон, төсвөөс давсан орлогын 50 хувийг ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд үлдээж байхаар зохицуулж иржээ.

1.34. НХХС-ын 2004 оны тушаалаар ХХҮГ-ын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсон ч үйл ажиллагааны санхүүжилтийг бүрдүүлэхэд дээрх журмыг хэвээр мөрдөж байгааг өөрчилж, гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний хураамж, ажлын байрны төлбөрөөс бүрдүүлж байгаа орлогыг

улсын төсөвт бүрэн төвлөрүүлж, ХХҮГ-ын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлын эх үүсвэрийг улсын төсвөөс гаргаж байх нь зүйтэй байна.

Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт, тайлагналд тавих хяналт сул байна

1.35. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд халамжийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглож, зөвхөн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхэд зарцуулна гэж заасан байхад НХХС-ын тушаалаар 2006 онд 203,3 сая төгрөгийн, 2007 онд 217,9 сая төгрөгийн дэвтэр, маягыг хэвлүүлэх зардлыг халамжийн сангаас санхүүжүүлсэн байна.

1.36. ХХҮГ-ын даргын 2006 оны 136 дугаар тушаалын дагуу хэлтсүүдээр дамжуулан олгох дэвтэр, маягтын үнийг тогтоохдоо хэвлүүлсэн зардлаас өндөр үнээр буюу 280 төгрөгийн дэвтрийг 450 төгрөгөөр, 18 төгрөгийн хувийн хэргийг 150 төгрөгөөр тогтоожээ. Энэ нь Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 14.1.4 дүгээр зүйлийн "... энэ хуульд заасныг зөрчиж нэмэлт бүтээгдэхүүн нийлүүлэх зэрэг аливаа хэлбэрээр орлого олохыг улсын төсвийн байгууллагад хориглоно" гэсэн заалт зөрчигджээ. Хэвлүүлсэн нийт дэвтэр, маягтын үнийн зөрүүг тооцож үзэхэд 78,4 сая төгрөг болж байна.

1.37. Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн дагуу эх, хүүхдийн тэтгэмж, шинэ гэр бүл, шинэ төрсөн хүүхэд, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж, хөрөнгийг халамжийн санд тайлагнаж байгаа нь Нийгмийн халамжийн тухай хуульд заасан нийгмийн халамж гэсэн тодорхойлолт, халамжийн сангийн зарцуулалтын төрөлд нийцэхгүй байна.

1.38. Нийгмийн халамжийн тухай хуулиар төрөлжсөн асрамжийн үйлчилгээний зардал амьжиргааг дэмжих санд хамаарч байгаа боловч асрамжийн үйлчилгээний санхүүгийн төсөв, гүйцэтгэлийг халамжийн санд бус НХХС-ын төсвийн багцад тусад нь тайлагнаж байгаа тул хуулийн заалтын дагуу тайлагнах нь зүйтэй байна.

1.39. БГД-ийн ХХҮХ-ээс Монголын тахир дутуу залуучуудын холбоо, Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, түүний харьяа Улаанбаатарын болон ХУД-ийн салбар зөвлөл, Монголын Тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо гэх мэт төрийн бус байгууллагуудын санал, хүсэлт болон ХХҮГ-ийн зөвшөөрлөөр 2005-2006 онд халамжийн сангаас тэргэнцэр, сонсголын аппарат, таяг зэрэг бараа материалыг олгосон боловч түүний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.



1.40. Халамжийн сангаас орон гэргүй өрхүүдэд гэр олгох тухай заалт Нийгмийн халамжийн тухай хуульд байхгүй. Гэтэл ХХҮГ-аас Халамжийн зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн аймаг, дүүргийн ХХҮХ-үүдэд халамжийн сангаас 2005 онд 156 гэр, 2006 онд 462 гэр, 2007 оны эхний 8 сарын байдлаар 251 гэр, бүгд 869 гэр олгох тушаал гаргаж хүргүүлжээ. Нэг гэрийг 650,0-750,0 мянган төгрөгөөр бэлтгэж, халамжийн сангаас зарцуулсан гэж үзвэл гэрийн үнэнд 608,3 орчим сая төгрөг зарцуулсан байна. /Хавсралт-5/

1.41. ХХҮГ-ын дээрх тушаал шийдвэрийг үндэслэн БГД-ийн ХХҮХ 2005-2007 онд 66.1 сая төгрөгийн үнэ бүхий 103 гэр, СХД-ийн ХХҮХ 2006-2007 онд 26.0 сая төгрөгийн үнэ бүхий 41 гэр, БЗД-ийн ХХҮХ 2006 онд 16.5 сая төгрөгийн үнэ бүхий 24 гэр тус тус олгожээ. Гэтэл БГД-ийн ХХҮХ-т "Ур дарх" ХХК-иас олгосон гэрийн жагсаалтад байгаа 11 дүгээр хорооны иргэн Д.Төмөрбаатар, А.Ундармаа, Б.Тунгалаг, 12 дугаар хорооны иргэн Р.Цэрэн нар гэр аваагүй гэсэн тайлбар өгсөн юм.



ТДОИХС-гийн харилцах дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдэж байгаа боловч тайлан тэнцэл гаргадаггүй, НХХЯ-нд өссөн дүнгээр гаргасан мэдээгээр тайлагнаж байна

1.42. НХХС, СЭЗС-ын 2004 оны 02/09 дүгээр тушаалаар баталсан "Тахир дутуу буюу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай дансыг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын дагуу "Тахир дутуу, одой иргэдийн хөгжлийн сан"-г байгуулж, зарцуулж иржээ.

1.43. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн дагуу "50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа гурав, түүнээс дээш орон тоонд тахир дутуу буюу одой хүн ажиллуулаагүй тохиолдолд" төлөх нөхөн төлбөрөөс дээрх сан бүрдэх ёстой.

1.44. ХХҮГ 2005, 2006 онд тусгай дансанд ХХҮХ болон ААНБ-аас хичнээн хэмжээний орлого төвлөрүүлэх талаар төлөвлөгөөгүй ажилласан бөгөөд харин 2007 онд НХХЯ-ны дэд сайд С.Чинзоригийн баталсан төлөвлөгөөгөөр дээрх аймаг, дүүргийн хэлтсүүдээс уг санд 254,2 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

1.45. 2007 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар БГД-ийн ХХҮХ 147 ААНБ-аас 842,8 сая төгрөг төвлөрүүлэхээс зөвхөн "Алтан дорнод" ХХК-иас 20,2 сая төгрөг төвлөрүүлж, 822,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Зөвхөн нэг дүүргийн ХХҮХ-ийн жишээнээс үзэхэд санг бүрдүүлэх бололцоог бүрэн ашиглахгүй байна.

1.46. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр заалт хангалтгүй хэрэгжиж байгаа шалтгааныг тогтоож, хуулийн заалтыг хэрэгжүүлэх талаар үр нөлөөтэй арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай юм. /Хавсралт-6/

1.47. ТДОИХСТД-нд төвлөрсөн хөрөнгөөс 2006 онд бүгд 133,8 сая төгрөгийн зардал гарсны 50,4 сая төгрөгийг аймаг, дүүргүүдийн ХХҮХ-ийн санхүүжилтэд, 83,4 сая төгрөгийг бусад арга хэмжээнд олгожээ.

1.48. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-д "... төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлж болно" гэж заасныг үндэслэн ХХҮГ доорх байгууллагуудад санхүүжилт олгосон байна. Үүнд:

- МТДИБҮХ-той энэ байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэхээр гэрээ байгуулж, 2006 онд 25,0 сая төгрөг, 11,6 сая төгрөгийн үнэ бүхий 11 компьютер, 2007 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үнэмлэхжүүлэх, судалгаа хийх болон тус байгууллагын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зориулалтаар 10,0 сая төгрөг, тоглолтын тасалбарын үнэ 1,5 сая төгрөг, бүгд 48,1 сая төгрөгийн санхүүжилт өгчээ.



- НХХЯ-ны сайд асан Л.Одончимэдийн шийдвэрээр массажны “Тайвшрал төв”-ийг байгуулахад зориулж Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоонд бүгд 30,0 сая төгрөг, 2007 онд тус яамны төрийн нарийн бичгийн дарга О.Байгалмаа гарын үсэг зурсан 3 талт гэрээг үндэслэн “Брайль” болон ярьдаг ном хэвлэх төв, хараагүйчүүдийн нөхөн сэргээх сургалтын төвийн 2007 оны үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх зориулалтаар 11,0 сая төгрөг, бүгд 41,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллаагүй байна. Үүний улмаас санхүүжилт авсан байгууллагууд хичнээн төгрөгийг ямар үйл ажиллагаанд зарцуулсныг тодорхойлох боломжгүй байна.

1.49. Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3-т “... төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бусад хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж заасныг зөрчиж 3,8 сая төгрөгийн үнэ бүхий 3 компьютер, 3 принтерийг ямар нэгэн шийдвэр, баримтгүйгээр Улсын мэргэжлийн хяналтын газарт хандивласан зөрчлийг арилгуулах, иргэн хувь хүмүүст олгосон 4,2 сая төгрөгийн үнэ бүхий 4 компьютерийг буцаан авах, авч чадахгүй тохиолдолд төлүүлэх нь зүйтэй байна.

1.50. Мөн тусгай сангийн хөрөнгөөс Сэргээн засалтын үндэсний төвд тухайн байгууллагын хүсэлтээр 2006 онд тоног төхөөрөмжийн зардалд 3,8 сая төгрөг, 2007 онд 2,9 сая төгрөг, “Бэрз интертаймент” ХХК-д заалны түрээсийн зардалд 1,0 сая төгрөг, интернетийн төлбөр болон товхимол хэвлүүлэхэд 0,9 сая төгрөг, 2007 онд НХХЯ-ны томилот, уулзалтын зардалд 0,8 сая төгрөг, бүгд 9,4 сая төгрөгийг гэрээгүйгээр санхүүжүүлж, зориулалт бусаар зарцуулжээ.

1.51. НХХС, Сангийн сайдын 2007 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 05/10 дугаар тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай дансыг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.2.4 “Ажил олгогчид тусгайлан ажлын байр бий болгох, хөгжлийн бэрхшээлийн онцлогт нийцсэн нэмэлт тоног төхөөрөмж худалдан авахад зориулж таван сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг нэг удаа олгох” гэсэн заалт зөрчигдсөн байна. Тухайлбал, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоонд Хараагүйчүүдийн нөхөн сэргээх сургалтын төвийн 2007 оны үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх зориулалтаар 11,0 сая төгрөг, МТДИБҮХ-нд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үнэмлэхжүүлэх, судалгаа хийх болон тус байгууллагын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зориулалтаар 10,0 сая төгрөг тус тус олгожээ.

1.52. Журмын 3.2.3-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10.3-т заасан зориулалт, нөхцөлөөр олгосон зээлийн хүүг эрх бүхий банк, банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-тай байгуулсан гэрээний үндсэн дээр нөхөн төлөх” гэж заасныг

зөрчиж ямар нэгэн гэрээ хэлцэлгүйгээр НХХЯ-ны дэд сайд С.Чинзоригийн 2007 оны 2/901 албан бичгийг үндэслэн зээл болон зээлийн хүү 4,6 сая төгрөгийг "Батуудын эхлэл" ХХК-д олгосон байна.

1.53. НХХС, СЭЗС-ын 2004 оны 02/09 дүгээр тушаалаар баталсан "Тахир дутуу буюу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай дансыг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын дагуу 2005 оноос эхлэн бүх аймаг, дүүргийн ХХҮХ-үүдэд дээрх тусгай дансыг нээж, ААНБ-уудаас ажлын байрны төлбөрийг төвлөрүүлэн зарцуулж, энэ талаархи мэдээ, тайланг сар бүр гаргаж ХХҮГ-т ирүүлж байсан боловч энэ сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг нягтлан бодох бүртгэлд тусгаж, тайлан тэнцэл гаргаж байсангүй.

1.54. Зарим дүүргийн ХХҮХ энэ сангийн гүйцэтгэлээр тайлан тэнцэл гаргаагүй, сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад дотоодын хяналт хангалтгүй хийгдэж байна. Тухайлбал, БГД-ийн ХХҮХ-ийн Тахир дутуу буюу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай сангаас 2005 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулж ажлын байр бий болгохтой холбогдуулан тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх зориулалтаар "Эверланд" ХХК-д 20,0 сая төгрөг олгогдсоныг хууль хяналтын байгууллага шалгаж байна.

Мэдээллийн баазын бүрдүүлэлт, ашиглалт хангалтгүй байна

1.55. 2005 онд "Халамжийн үйлчилгээний менежер програм" боловсруулагдсан боловч батлагдаагүйгээс түүнийг ашиглах заавар, аргачлал туршигдаж, нэвтрээгүй байна. Гэтэл нийслэлийн ХХҮХ-үүд сонгон шалгаруулалтгүйгээр "Ритус" ХХК-ийн боловсруулсан "Хөдөлмөр, халамж-2006" програмыг ашиглаж байна.

1.56. ХХҮГ болон аймаг, дүүргийн ХХҮХ-үүдийг холбосон сүлжээгүйгээс оршин суугаа газраа өөрчилсөн иргэдийг халамж, тусламжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргахад хуучин харъяалагдаж байсан ХХҮХ болон орон нутгийн байгууллагаас тодорхойлолт авчруулж байгаа нь үйлчилгээнд давхардал гарах эрсдэлийг бууруулж байгаа боловч иргэдэд чирэгдэл учруулж байгаа тул үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох шаардлагатай.

1.57. ХХҮГ-аас халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн үйлчилгээнд хамрагдах иргэд, үйлчлүүлэгчийн тоог гаргахад ҮСГ, ИБМУТ-өөс гаргасан тоон мэдээлэлтэй тохирохгүй, харилцан хүлээн зөвшөөрөгдөхгүй байх тохиолдол гарч байна.

Бүлэг 2 Тогтвортой ажлын байр бий болж, ажилгүйчүүдийн тоо буурсан гэх бодитой үзүүлэлт алга байна

2.1. ЗГ-ын 2006 оны 159 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, НХХС-ын 2006 оны 80 дугаар тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын төрөл, хамрагдах иргэнд тавигдах нөхцөл, болзол, шалгуурыг тодорхойлох журам” шинэчлэн батлагдсан байна.



Ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулийн дагуу шийдвэрлэж байх шаардлагатай

2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар ХЭДС-г хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ болон арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулахаар хуульчилсан.

2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлд ХЭДС-гийн орлогыг 8 төрлийн эх үүсвэрээс бүрдүүлэхээр заасан байна.

2.4. 2006 оны нийт орлогын 98.3 хувь буюу 6.4 тэрбум төгрөгийг гадаад иргэдийн АБТ, 1.7 хувь буюу 108.9 сая төгрөгийг зээлийн эх үүсвэрт ногдуулсан хүүгийн орлого, орон нутгийн төсвийн дэмжлэг болон бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн байна. 2006 оны АБТ-ийн орлого өмнөх оноос 2.6 тэрбум төгрөгөөр өсчээ.

Орлогын бүрдэлт	2005 оны гүйцэтгэл	/сая төгрөгөөр/ 2006 он	
		Төлөв	Гүйц
ОНТ-ийн санхүүжилт	1.6	0	2.4
Ажлын байрны төлбөр	3736.0	5800.0	6411.7
Жижиг зээлийн сангийн хүү	120.5	90.0	87.9
Бусад	15.2		18.6
Дүн	3873.3	5890.0	6520.6

2.5. ХЭДС-д улсын төсөв болон ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогоос хуулийн дагуу зарцуулах хөрөнгө, сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, гадаад улс, олон улсын байгууллага, ААНБ, ТББ, иргэдээс өгөх хандив тусламжаас орлого төвлөрөөгүй байна.

АБТ-ийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн байдал

Үзүүлэлт	2005 он	2006 он	2007.07.01
Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон тоо	14,283	23,355	15,175
АБТ төлсөн тоо	9,621	17,077	9,261
АБТ-өөс чөлөөлөгдсөн тоо	4,662	6,278	5,914
Чөлөөлөгдсөн дүн /сая.төг/	3,415.0	5,876.7	5,243.1

2.6. “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн 9.5, 9.6 дугаар заалт, ЗГ-ын 2001 оны 139 дүгээр тогтоолыг үндэслэж ХХҮГ Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа

зарим ААНБ, иргэнд гадаадын иргэдийн АБТ-өөс 2005 онд 4662 хүний 3415,0 сая төгрөг, 2006 онд 6278 хүний 5876,7 сая төгрөг, 2007 оны эхний хагас жилд 5914 хүний 5243,1 сая төгрөг, бүгд 16854 хүнтэй холбоотой 14,534.8 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлжээ.

2.7. Дээрх тоо баримтаас харахад гадаадын иргэдтэй холбоотой ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдөх хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа бөгөөд ялангуяа 2007 онд 2005 оноос 3 дахин, 2006 оноос 2 дахин нэмэгдэх хандлагатай байна.

2.8. АХГГАХМАТ хуульд заагдаагүй заалт ЗГ-ын 139 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-д тусгагдаж, улмаар энэ заалтыг үндэслэн АБТ-өөс чөлөөлж, хөнгөлөлт үзүүлж байна.

2.9. Боловсролын салбарт ажиллах гадаадын иргэдийн талаар хууль болон журамд дараахь байдлаар тусгагджээ:

АХГГАХМАТ хуулийн заалт	“Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам” –ын заалт
“... боловсрол, шинжлэх ухааны салбарт гэрээгээр ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн, ажилтнууд, ЗГ хоорондын гэрээнд заасан тохиолдолд уг гэрээгээр ажиллаж байгаа мэргэжилтэн, ажилтнуудад ... заасан төлбөр хамаарахгүй	“... боловсрол, шинжлэх ухааны салбарт гэрээгээр ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн, ажилтнууд чөлөөлөгдөнө”.

- ЗГ хоорондын гэрээ хэлэлцээртэй эсэхийг харгалзахгүйгээр боловсролын салбарт ажиллаж байгаа 993 гадаадын мэргэжилтний 968,8 сая төгрөгийг АБТ-өөс чөлөөлсөн байна.

2.10. Түүнчлэн улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга, байгууламж барих... гэдэг нэрийн дор бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа зарим аж ахуйн нэгж, байгууллагууд ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдөж байна. Хууль болон журмын холбогдох заалтыг үзүүлбэл:

АХГГАХМАТ хуулийн 7 дугаар зүйлийн Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээнд тусгах ерөнхий нөхцөлүүд	"Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам" –ын 3 зүйлийн заалт
"Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга, байгууламж барих ... ЗГ-ын шийдвэрийг үндэслэн гадаадаас ажиллах хүч авна" гэж заасан нь хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамаарахгүй заалт	"Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга, байгууламж барих ... ЗГ-ын шийдвэрийг үндэслэн гадаадаас ажиллах хүч авна" гэж заасан /АХГГАХМАТ хууль/

Хуулиар АБТ-өөс чөлөөлөгдөхөөр заагаагүй байхад журамд заалт оруулснаар зарим ААНБ хөнгөлөлт эдэлж байна. Тухайлбал,

- Орон сууцны барилга барьж байгаа "Богда-холдинг" ХХК" 2006 онд НХХС-ын 124 дүгээр тушаалаар 250 иргэний төлбөр 119,2 сая төгрөг, НХХС-ын 2007 оны 59 дугаар тушаалаар 300 ажилтны төлбөр 186,3 сая төгрөг, бүгд 305,5 сая төгрөгийн,
- Дорнод аймгийн Тамсагт газрын тосны хайгуул, олборлолт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа эрхэлж байгаа БНХАУ-ын "Петро Чайна Дачин" ХХК 2006 онд ЗГ-ын тогтоол, шийдвэргүйгээр бүтээгдэхүүн хуваах гэрээг үндэслэн 1435 иргэний төлбөр 1352,6 сая төгрөг, 2007 онд ЗГ-ын 59 дүгээр тогтоолоор 3620 иргэний төлбөр 4745,8 сая төгрөг, бүгд 6098,4 сая төгрөгийн,
- Дорноговь аймгийн Зүүнбаянгийн сав газарт газрын тосны хайгуул, олборлолт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа эрхэлж байгаа "Доншен газрын тос" ХХК 2006 онд Бүтээгдэхүүн хуваах гэрээг үндэслэн 421 иргэний төлбөр 291,0 сая төгрөг, 2007 онд ЗГ-ын 59 дүгээр тогтоолоор 480 ажилтны төлбөр 629,2 сая төгрөг зэрэг бүгд 920,2 сая төгрөгийн төлбөрөөс тус тус чөлөөлөгджээ.

2.11. АХГГАХМАТ хуулийн 9.5, 9.6 дугаар зүйлд заасан зарим заалтыг зөрчсөн ЗГ-ын 2001 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг өөрчилж, гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг зөвхөн хуулийн дагуу шийдвэрлэж байх шаардлагатай байна.

2.12. Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөр хураамжийн үйл ажиллагаанд тавих хяналт бүрэн хийгдээгүйгээс 2006 онд БНХАУ-ын "Икс Ди Эф" компанийн 102 хүн, "Монголхо Цэн" компанийн 20 хүн, "Лиаошинан" компанийн 16 хүний ажлын байрны төлбөртэй холбоотой асуудлыг ХХҮГ-ын холбогдох албаар дамжуулалгүйгээр тус газрын дэд дарга Ж.Цогтбаатар зөвшөөрөл олгосныг хууль хяналтын байгууллага шалгаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг үр нөлөөтэй зарцуулах боломж байна

2.13. 2006 онд ХЭДС-гаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд нийт 4.2 тэрбум төгрөг зарцуулж, 169.8 гаруй мянган хүнийг хамруулжээ. 2006 онд ХЭДС 4.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь илүү үр ашигтай хэлбэрээр олон хүнийг хамруулах боломжтой байсныг харуулж байна.

Үзүүлэлт	2005 оны гүйц		2006 оны гүйц	
	үйлч/тоо	хөрөнгө	үйлч/тоо	хөрөнгө
Сангийн нийт зарлага	142,230	3,247.0	169,863	4,251.3
Мэргэжлийн баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах	55,537	94.2	71,581	113.0
Ажилд зуучлах	44,955	61.5	44,606	108.5
Мэргэжил олгох, давтан сургалтад хамруулах	19,493	787.7	25,938	1,055.6
НХА зохион байгуулах	17,877	678.3	17,940	799.3
Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэх иргэнийг дэмжих	3,012	1,050.5	8,614	1,565.4
Үүнээс: Жижиг зээл олгох	3,012	1,050.5	7,161	1,514.7
АОДАХ	1,356	274.5	1,184	276.3
ХЭА-дын материаллаг баазыг бэхжүүлэх, ажилтнуудын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэхэд		300.3		333.2

2.14. ХЭДС-гийн 2006 оны зарцуулалтаас үзэхэд мэргэжлийн сургалт, жижиг зээл, нийтийг хамарсан ажил, байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэхэд нийт хөрөнгийн 87.2 хувийг зарцуулжээ. Харин ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах, АОДАХ-нд 12.8 хувийг зарцуулсан нь ХЗЗ-ийн бодлогын гол арга хэмжээний хувьд харьцангуй бага хөрөнгө юм. Мөн хөдөлмөр эрхлээгүй иргэдийн судалгаа гаргах, шинэ үйлчилгээ турших, нэвтрүүлэх үйл ажиллагаа хийгдээгүй байна.

2.15. ХЭДТХ-иар сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнээс бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно гэж заажээ. Харин ЗГ-ын 159 дүгээр тогтоолоор баталсан журмын 4.1.9-т "... орлогын тухайн жилийн төлөвлөгөөнөөс давсан хэсгийг Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын хэвийн ажиллагааг хангах, ажилтнуудаа сургах, давтан сургах, урамшуулахад зарцуулах"-аар тогтоосон нь хуулийн заалттай зөрчилдөж байгаа тул уг үйл ажиллагааны зардлыг НХХС-ын төсвийн багцад тусган батлах нь зүйтэй.

Нэгж	Татсан эх үүсвэр	Нэмж олгосон	Эцсийн үлдэгдэл
Банк	2,000.0	3,700.0	3,700.0
ББСБ	540.0	310.0	310.0
Дүн	2,540.0	4,010.0	4,010.0

Зээлийн эх үүсвэрийн хэмжээ нэмэгдсэн ч түүний ашиглалт хангалтгүй, ажлын байрны мэдээллийн сан бүрдээгүй байна

2.16. Банк, ББСБ-тай байгуулсан гэрээний дагуу байршуулсан хөрөнгийн 2006 оны эхний үлдэгдэл 2540,0 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 4010.0 сая төгрөг болж зээл олгох эх үүсвэр нэмэгдсэн байна.

2.17. 2006 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар банк, ББСБ-уудад байршуулсан эх үүсвэрээр 3.5 тэрбум төгрөгийн зээлийг 2414 зээлдэгчид олгосныг зээлдэгчээр авч үзвэл 36.8 хувийг албан бус хөдөлмөр эрхлэгчид, 5.6

Нэгж	Зээлийн хэмжээ /сая.төг/	Албан бус хөд/эрх	Ажилгүй иргэн	Малчин	ААН	Иргэн	Өрх	Малчин өрхүүдийн бүлэг
Банк	3,033.3	772	396	129	95	561	6	18
ББСБ	504.5	117	44	6	18	216	9	27
Бүгд	3,537.8	889	440	135	113	777	15	45

хувийг малчдад, 4.7 хувийг аж ахуйн нэгжид, 32.1 хувийг иргэнд, 0.6

хувийг өрхөд, 1.9 хувийг малчин өрхүүдийн бүлэгт, 18.2 хувийг ажилгүй иргэнд олгожээ.

2.18. 2006 оноос зээлийн эх үүсвэрийн ашиглалтад анх удаа хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэсэн бөгөөд ББСБ-ууд аудитад хамрагдаагүй байна. Уг аудитын дүнгээс үзэхэд 2007 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар "ХААН" банкинд 319.3 сая, "Капитал" банкинд 348.2 сая, "Монгол шуудан" банкинд 286.2 сая төгрөгийн олгогдоогүй, зээлийн эх үүсвэр ашиглагдаж байжээ.

2.19. "Анод" банк 2005 онд байршуулсан эх үүсвэрээр 3 сар гаруй хугацаанд зээл олгоогүй тул гэрээг цуцлан эх үүсвэрийг татаж байсан ч 2006 онд 500.0 сая төгрөгийн эх үүсвэрийг дахин байршуулжээ. 2006 онд "Голомт" банкнаас 500.0 сая, "Мон-Арвис" ББСБ-аас 40.0 сая, "Фин инвест" ББСБ-аас 50.0 сая төгрөгийн ашиглалтгүй байсан эх үүсвэрийг буцаан татаж байжээ.

2.20. Банк, ББСБ-аас зээл олгоход зээлийн эрсдэлийг бүрэн хариуцаж байгаагаас өндөр шаардлага тавьж, зээлийн эх үүсвэр бүрэн хэмжээгээр ашиглагдахгүй байна. Нөгөө талаас үр ашигтай төслийг санхүүжүүлэх бололцоо багасч байна.

2.21. ХХҮГ-аас банк, ББСБ-уудын зээлдэгчийг сонгон шалгаруулах, тогтвортой ажлын байр бий болгох зорилгод чиглэгдсэн зээл олголтын үйл ажиллагаанд оролцоогүй, зөвхөн мэдээгээр хязгаарлагдаж байгаа нь энэ чиг үүргийн хэрэгжилт хангалтгүйг харуулж байна.

2.22. Жижиг зээл олгох журмын дагуу хөдөлмөр эрхлэлтийн болон санхүүгийн байгууллага, зээлдэгчийн гурван талын гэрээ хийгдэхгүй, гурвалсан гэрээг зөвхөн лизингийн зээл олгох үед байгуулах зарчмыг баримталж байгаа гэх боловч 2006 онд уг зорилтод чиглэгдсэн зээл олгогдоогүй байна.

2.23. ХЭДС-гаас зээл олгох, зээлийн хүүг нөхөн төлөх журмын дагуу шинээр бий болгох, өргөтгөх ажлын байрны талаар зээлдэгчтэй байгуулсан гэрээг үндэслэн мэдээллийн нэгдсэн санг байгуулах ёстой ч уг санг бүрдүүлээгүй байна.

2.24. ХЭДС-гаас байршуулсан эх үүсвэрээр жижиг зээл олгох үйл ажиллагаанд банк, ББСБ-тай байгуулсан гэрээгээр хагас жил тутам хяналт тавьж хамтран ажиллах ёстой боловч энэ ажил хийгдээгүй байна.

Мэргэжлийн сургалт олгох үйл ажиллагаанд тавих хяналт орхигджээ

2.25. ХХҮГ “Эрхийн бичгээр сургалт зохион байгуулах журам”-ын дагуу хяналт тавих ёстой атал тендерт шалгарсан МСТ-үүдийн сургалтын явцад хяналт тавих үүргийг ХХҮГ-аас Жижиг дунд үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо, Барилгын инженерүүдийн холбоо зэрэг ТББ-уудад хүлээлгэжээ.

2.26. Түүнчлэн “Бизнес инкубацийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх журам”-д зааснаар ХЭДС-гаас Бизнес инкубаторийн төв болон зөвлөгөө өгөх төвийг сонгон шалгаруулж, тэдгээртэй хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг ХХҮГ зохион байгуулна гэж заасан боловч үйлчилгээнд хамруулах ААН, иргэнийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа хийгдээгүй байна.

Үйлчилгээ, арга хэмжээний зардлын гүйцэтгэлд хяналт тавихгүй байна

2.27. ХЭДС-гийн 2006 оны тайлагнал болон ХХҮХ-үүдээс ирүүлсэн мэдээ, сангийн зарцуулалтад хийсэн судалгаагаар зөвхөн ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах арга хэмжээнд 71.5 мянган хүнийг хамруулсан гэсэн мэдээ гарч байгаа ч энэ нь 2006 онд ХХҮХ-үүдэд бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн тоотой зэрэгцүүлэхэд 38.6 мянган хүнээр илүү байна.

2.28. Гэтэл ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээллээр хангах үйлчилгээнд нэг үйлчлүүлэгчээр тооцсон дундаж зардал Хөвсгөл аймагт 9279 төгрөг, Дархан-Уул аймагт 4825 төгрөг, Увс аймагт 773 төгрөг, Сүхбаатар дүүрэгт 2368 төгрөг, Хан-Уул дүүрэгт 263 төгрөг, ажилд зуучлах арга хэмжээнд Багануур дүүрэгт 6056 төгрөг, Баянгол дүүрэгт 5615 төгрөг, Багахангай дүүрэгт 217 төгрөг, Хөвсгөл аймагт 563 төгрөг, Өвөрхангай аймагт 3548 төгрөгийн зардал тус тус гарсан байна.¹ /Хавсралт-7/

2.29. 2005 онд зээл олголтоор бий болгосон ажлын байрны дундаж өртөг 700.0 мянган төгрөг байхад “ХАС” банк 1114.3 мянга, “Голомт” банк 1475.2 мянга, “Анод” банк 4932.5 мянга, “Тод санаа” ББСБ 993.4 мянга, “Эрхэс сан” ББСБ 974.3 мянга, “Фин инвест” ББСБ 4987.0 мянган төгрөгөөр тус тус нэг ажлын байрыг бий болгожээ. 2006 онд ажлын байрны дундаж өртөг 765.0 мянган төгрөг байхад “Голомт” банк 1686.7 мянган төгрөгөөр, “Инвест кредит” ББСБ 2161.1 мянган төгрөгөөр, “Мастер инвест” ББСБ 1299.0 мянган төгрөгөөр нэг ажлын байр бий болгожээ.

2.30. Үйлчилгээ, арга хэмжээний зардал харилцан адилгүй гарч байгаа болон зардлын гүйцэтгэл бодитой эсэхэд хяналт, шинжилгээ хийгээгүй байна.

2.31. ХЭДС-гийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүйгээс энэ сангаас зориулалт бусаар зарцуулах явдал гарч байна. Тухайлбал, ХХҮГ-ын жолоочийн (тухайн үед өөр хүн жолоодож байсан) хариуцаж байсан УБЗ 06-28 улсын дугаартай Ланд круйзер-105 авто машиныг эвдэж байгууллагад 3865,2 мянган төгрөгийн хохирол учруулсныг эзэн холбогдогчоор төлүүлэлгүй сангийн хөрөнгөөс гаргажээ.

¹ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2006 оны зардлын гүйцэтгэлийн мэдээ

2.32. Ажил эрхлэлтийн 2005 оны жилийн эцсийн тайлангаар улсын хэмжээнд нийтдээ 260.0 мянган хүн хөдөлмөр эрхлээгүй² байна. Үүнээс хүндэтгэх шалтгаанаар ажил эрхлээгүй хүмүүсийг хасвал 160.0 гаруй мянган хүн тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй байна.

2.33. Энэ үзүүлэлтийг ХХҮХ-үүдэд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоотой харьцуулахад нийт ажилгүйчүүдийн зөвхөн 12.6 хувийг хамарч байгаа нь үйлчилгээ, арга хэмжээ хүртээмжтэй хүрч, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн гэж үзэх боломжгүй байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг судалж байгаа боловч нийт эрэлт, нийлүүлэлтийн харьцаа бүрэн илэрхийлэгдэхгүй байна

2.34. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ХХҮХ-үүдэд ажил олгогч байгууллагаас ирүүлсэн захиалгын мэдээгээр, нийлүүлэлтийг ажилд зуучлан оруулсан хүний тоогоор тус тус гарган эрэлт, нийлүүлэлтийн харьцааг тодорхойлж байна. ХХҮГ сүүлийн 5 жилийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг дараахь байдлаар тодорхойлжээ:



2006 онд ХХҮХ-үүд 43092 хүн ажилд зуучлан оруулсныг улсын хэмжээнд статистикийн³ мэдээллээр гарсан ажил эрхэлдэггүй 610,0 мянган хүн амтай харьцуулахад 7.0

хувийг эзэлж байгаа нь Х33-ийн эрэлт, нийлүүлэлтийг бүрэн илэрхийлэхгүй байна.

Үзүүлэлт	2003	2004	2005	2006
ХНХА	1,488.9	1,531.1	1,577.0	1,619.6
ЭЗИХА	959.8	986.1	1,001.2	1,042.8
Ажиллагчид	926.5	950.5	968.3	1,009.9
Бүртгэлтэй ажилгүйчүүд	33.3	35.6	32.9	32.9
Ажилгүйдлийн түвшин %	3.5	3.6	3.3	3.2

2.35. Сүүлийн 4 жилийн байдлаар ажилгүйдлийн түвшний үзүүлэлт бараг өөрчлөлтгүй буюу 3,2-3,6 хувьтай байгаа нь ажилгүйдэл буурахгүй байгааг харуулж байна. Мөн эдийн засгийн идэвхтэй хүн амын болон ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоотой харьцуулсан үзүүлэлтээр

хөдөлмөрийн нөөц бүрэн хэмжээгээр ашиглагдахгүй байна. **Графикаар үзүүлбэл:**

² Үндэсний статистикийн газрын 2006 оны 12 дугаар сарын мэдээ
³ Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2006 он



2.36. Дээрх графикаар хүн амын ажил эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд өсөлт багатай, нэг түвшинд тогтмол байна.

2.37. Харин 2006 оны хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын мэдээгээр нийт 59584 ажилгүй иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлээс 59789 хүн хасагджээ. Сүүлийн 3 жилийн бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоонд 2 жилээс дээш хугацаагаар бүртгэлтэй байгаа ажилгүйчүүдийн тоо ихэнх хувийг эзэлж байна. Хэрэв 30 хоногийн дотор ажил хайгч иргэн ХХҮХ-т эргэн хандаагүй тохиолдолд ашиглагдаж буй програмын дагуу бүртгэлээс хасагддаг байна.

Хугацаа	2004	2005	2006
1 хүртэл сар	3,207	2,918	4,160
1-3 хүртэл сар	4,678	5,229	4,493
3-6 хүртэл сар	3,560	2,879	4,612
6-12 хүртэл сар	8,025	5,521	5,197
12-24 хүртэл сар	8,133	6,334	4,173
24-өөс дээш сар	8,548	9,437	9,503
Дүн	35,073	31,503	32,138

2.38. ХЗЗ-ийн эрэлт, нийлүүлэлтийн харьцааг бодитой илтгэхэд зайлшгүй хамаарал бүхий зарим асуудлууд байна. Тухайлбал, сул чөлөөтэй ажиллах хүчний бүтэц болоод ажилгүйдлийн төрлөөр нарийвчилсан судалгаа хийдэггүй, хөдөлмөрийн насны хүн амын дүнд хамаарах албан бус салбарын хөдөлмөр эрхлэлт болон мэргэжлийн ажиллах хүчин шаардлагатай байгаа эдийн засгийн салбар дахь ажиллах хүчний хэрэгцээнд нийцсэн судалгаа, тооцоолол, бодлогын асуудал хөндөгдөхгүй байна.

2.39. ХЭДС-гаас зарцуулсан хөрөнгө 2005 онд 3.2 тэрбум төгрөг, 2006 онд 4.2 тэрбум төгрөг болж жилээс жилд өсөн нэмэгдэж байхад ХХҮХ-үүдэд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 32.9 мянган хүн буюу өнгөрсөн онтой харьцуулахад дөнгөж 11 хүнээр буурсан байна. Иймд ХХҮГ хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна:

Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярт:

- Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн заалттай зөрчилдсөн Засгийн газрын 2001 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан "Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам"-ыг өөрчилж, цаашид ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэж байх,

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэлд:

- ХХҮГ-ын хуулиар хүлээсэн чиг үүргийг бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнд бүрэн тусгуулж байх;
- Гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний хураамж, ажлын байрны төлбөрөөр бүрдүүлж байгаа орлогыг улсын төсөвт бүрэн төвлөрүүлж, ХХҮГ-ын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын болон ХЭДС-гийн зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвөөс гаргаж байх арга хэмжээ авах.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Баярсайханд

- ХХҮХ-ийн орон тоог үйлчилгээний хэмжээ, ажлын ачаалалтай уялдуулан одоогийн нөөцийн хүрээнд оновчтой хэлбэрээр зохион байгуулах;
- Тусгай сангийн хөрөнгөөр бараа, материал бэлтгэх явдлыг бүрэн зогсоох, санг бүрдүүлэх, зарцуулах, үйлчилгээнд тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, олон нийтэд ил тод сурталчилж байх;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдагсдын мэдээллийн санг бий болгох, нийгмийн халамжийн үйлчилгээнд програм хангамжийг нэвтрүүлэн ажиллах.

Нийгмийн хамгаалал, хөдлөмрийн яамнаас ирүүлсэн санал:

Аудитын тайлангийн төсөлд өгөх санал байхгүй гэж ирүүлээгүй болно.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хувьсгалчдын гудамж 14, Утас: 26-02-19,
Факс: (976-11) 32-79-06, E-mail: ceo@mongolnet.mn

2009.11.14 № 27/1189
танай _____ -ны № _____ -Т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

3/390 тоотын хариу

Үндэсний аудитын газраас ХХҮГ-ын үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайланд хийж байгаа үндсэн дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, бидний үйл ажиллагааны явцад анхаарах, цаашид засч залруулах асуудлаар үнэтэй санал, зөвлөмжийг өгч байгаа нь их ач холбогдолтой болж байна.

Тайлангийн төсөлд зарим үйл ажиллагааны чиглэлээр өгч байгаа дүгнэлтэд холбогдох хариулт, тодруулгыг доорхи байдлаар гаргаж байна. Үүнд:

1. ХХҮГ-ын үйл ажиллагааны дотоод хяналт, мэдээллийн тогтолцоо хангалтгүй байна гэж дүгнэжээ. Халамжийн үйлчилгээг зохион байгуулахтай холбогдсон мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгох программ хангамжийг боловсруулан хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.
2. Тайлангийн 1,44 –т дурдсан дүгнэлтэд тайлбар өгөхөд одоогийн ХХҮГ-ын дүрэмд Нийгмийн халамжийн зөвлөлийг дэргэдээ байгуулахыг заасан байдаг. Энэхүү заалтын дагуу зөвлөл нь иргэд, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хэлэлцэн харъяа хэлтсүүдээр дамжуулан асуудлыг шийдвэрлэдэг. Ирж байгаа өргөдөл, хүсэлтийн дийлэнх нь орон гэр олгох, эмчилгээний зардал хүссэн байдаг. Нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн бодит хэрэгцээ болсон орон гэр олгох асуудал нь олон жилийн турш уламжлагдан ирж, иргэдээс ихээхэн талархалд дэмжлэг хүлээсэн арга хэмжээ болсон юм.
3. Тайлангийн 2,23- т хийсэн дүгнэлтэд дурдсан мэдээллийн санг бүрдүүлэх ажлын программ хангамж үндсэндээ боловсрогдон одоогоор туршилтын журмаар мэдээллийн санг бүрдүүлж эхлээд байна. Цаашид программ хангамжийг бүрэн ашиглаж мэдээллийн санг бүрдүүлэх боломжтой болсон.
4. Тайлангийн 2,26-т дахь дурдсан гэрээ байгуулах ажил хийгдсэн байгаа. Цаашид гэрээний заалтыг боловсронгуй болгох, хяналтыг тавих ажилд анхаарч ажиллах болно.



Д.БАЯРСАЙХАН

057869

Хавсралт-1

2004-2006 онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, мөнгөн тусламжид хамрагдагсдын судалгаа /үйлчлүүлэгчийн тоогоор/

Д.д	Аймаг, нийслэлийн дүүрэг	Үйлчилгээ авсан нийт хүний тоо /хүн/			Үйлчлүүлэгчийн тоог өмнөх онтой зэрэгцүүлснээр		Суурин хүн амын тоо /мян.хүн/		Хүн амын өсөлт 2006/2005	Суурин хүн амд үйлчилгээ авсан хүн амын эзлэх хувь	
		2004	2005	2006	2005/2004	2006/2004	2005	2006		2005	2006
1	Архангай	14,954	41,165	56,188	26,211	15,023	93.8	93.3	(0.5)	43.9	60.2
2	Баянхонгор	14,698	50,826	58,856	36,128	8,030	83.6	83.8	0.2	60.8	70.2
3	Баян-Өлгий	18,591	50,817	65,042	32,226	14,225	100.0	100.1	0.1	50.8	65.0
4	Булган	10,420	24,297	31,009	13,877	6,712	59.9	60.3	0.4	40.6	51.4
5	Говь-Алтай	7,173	29,345	34,737	22,172	5,392	60.4	60.3	(0.1)	48.6	57.6
6	Дорноговь	7,516	15,556	29,694	8,040	14,138	53.3	54.5	1.2	29.2	54.5
7	Дорнод	11,870	29,854	44,113	17,984	14,259	73.4	73.6	0.2	40.7	59.9
8	Дундговь	7,656	19,813	29,457	12,157	9,644	49.6	49.2	(0.4)	39.9	59.9
9	Завхан	12,466	39,350	47,878	26,884	8,528	80.1	80.6	0.5	49.1	59.4
10	Өвөрхангай	22,138	56,035	65,423	33,897	9,388	113.8	114.9	1.1	49.2	56.9
11	Өмнөговь	10,007	24,804	33,383	14,797	8,579	46.1	46.5	0.4	53.8	71.8
12	Сүхбаатар	7,539	22,077	33,362	14,538	11,285	56.0	55.6	(0.4)	39.4	60.0
13	Сэлэнгэ	13,893	42,477	52,271	28,584	9,794	99.8	100.1	0.3	42.6	52.2
14	Төв	15,680	31,502	50,790	15,822	19,288	87.4	86.4	(1.0)	36.0	58.8
15	Увс	24,384	50,428	60,733	26,044	10,305	80.6	80.5	(0.1)	62.6	75.4
16	Ховд	18,417	46,146	54,153	27,729	8,007	87.9	88.5	0.6	52.5	61.2
17	Хөвсгөл	24,918	64,083	83,794	39,165	19,711	121.7	122.1	0.4	52.7	68.6
18	Хэнтий	13,235	29,915	41,975	16,680	12,060	70.8	71.0	0.2	42.3	59.1
19	Дархан-Уул	12,443	36,238	49,967	23,795	13,729	87.7	87.5	(0.2)	41.3	57.1
20	Орхон	10,897	32,719	45,820	21,822	13,101	79.0	79.4	0.4	41.4	57.7
21	Говьсүмбэр	2,728	6,177	8,374	3,449	2,197	12.2	12.3	0.1	50.6	68.1
22	Налайх	12,395	11,577	17,081	(818)	5,504	25.3	27.3	2.0	45.8	62.6
23	Багануур	6,585	10,992	16,142	4,407	5,150	24.9	25.7	0.8	44.1	62.8
24	Сүхбаатар	8,233	23,607	48,306	15,374	24,699	120.2	123.6	3.4	19.6	39.1
25	Чингэлтэй	13,206	30,544	51,078	17,338	20,534	131.5	132.9	1.4	23.2	38.4
26	Баянзүрх	20,990	46,325	79,750	25,335	33,425	184.7	211.6	26.9	25.1	37.7
27	Хан-Уул	9,294	21,265	37,858	11,971	16,593	89.1	91.9	2.8	23.9	41.2
28	Сон/хайрхан	15,127	47,946	86,150	32,819	38,204	211.1	213.1	2.0	22.7	40.4
29	Баянгол	8,791	25,084	57,166	16,293	32,082	160.5	164.3	3.8	15.6	34.8
30	Багахангай	1,537	1,994	2,806	457	812	3.9	3.9	-	51.1	71.9
31	ХХҮГ	987	150	196	(837)	46			-		
	Дүн	378,768	963,108	1,373,552	584,340	410,444	2,548.3	2,594.8	46.5	37.8	52.9

Хавсралт-1.1

Нийгмийн халамжийн сангийн 2006 оны төсөв, гүйцэтгэл

/мян.төг/

Халамжийн сан	2006 оны		Зөрүү
	Төсөв	Гүйцэтгэл	
Халамжийн тэтгэвэр	10,414,413.1	12,024,243.2	1,609,830.1
Жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмж	4,345,110.0	3,817,094.0	(528,016.0)
Нярай хүүхэдтэй эхийн тэтгэмж	143,191.0	82,645.3	(60,545.7)
Хүүхдийн арчилгааны тэтгэмж	7,452,000.0	7,200,012.8	(251,987.2)
Ихэр хүүхдийн тэтгэмж	14,364.0	5,784.8	(8,579.2)
Бүтэн өнчин хүүхэд үрчилсний тэтгэмж	47,401.2	92,447.7	45,046.5
Өндөр настан, ахмад дайчдад хөнгөлөлт	2,197,317.0	2,422,497.8	225,180.8
Тахир дутуу хүмүүст үзүүлэх хөнгөлөлт	987,938.2	1,034,871.0	46,932.8
Улсын баатар болон одонгийн шагнал	77,805.0	173,785.8	95,980.8
Халамжийн бусад хөнгөлөлт үйлчилгээ	369,658.7	365,297.2	(4,361.5)
Ахмад дайчдад олгох нэг удаагийн тусламж	378,200.0	482,161.0	103,961.0
Олон хүүхэдтэй гэр бүлд олгох тэтгэлэг	29,628,000.0	26,249,358.0	(3,378,642.0)
Залуу гэр бүл хөтөлбөр	6,400,000.0	11,814,000.0	5,414,000.0
Алдарт эхийн одонтой эхчүүдэд тусламж	6,039,000.0	4,908,491.5	(1,130,508.5)
Шинээр төрсөн хүүхдэд олгох тэтгэмж	4,550,000.0	4,111,000.0	(439,000.0)
Төсвийн зээл /Халамжийн тэтгэвэрт/	1,544,299.9		(1,544,299.9)
Маягтын зардал		243,518.4	243,518.4
Банкны үйлчилгээний хураамж	158,000.0	374,024.4	216,024.4
Нийт дүн	74,746,698.1	75,401,232.9	654,534.8

Хавсралт-1.2

2006 онд гэр бүл, хүүхдийн мөнгөн тусламжид хамрагдагсдын судалгаа

/мян.төг/

Д.д	Аймгийн нэр	Хүн амын тоо /мян.хүн/	Гэрлэсэн гэрлэгчдийн тоо	2006 онд тусламжид хамрагдсан гэр бүлийн		Шинээр төрсөн тоо	2006 онд тусламжид хамрагдсан хүүхдийн	
				тоо	хөрөнгө		Тоо	хөрөнгө
1	Архангай	93,300.0	1,735	867	433,500.0	1,697	1,497	149,700.0
2	Баянхонгор	83,800.0	1,530	716	358,000.0	1,530	1,348	134,800.0
3	Баян-Өлгий	100,100.0	1,681	1,414	707,000.0	2,291	2,541	254,100.0
4	Булган	60,300.0	1,270	702	351,000.0	990	855	85,500.0
5	Говь-Алтай	60,300.0	951	514	257,000.0	1,244	977	97,700.0
6	Дорноговь	54,500.0	1,035	473	236,500.0	1,112	961	96,100.0
7	Дорнод	73,600.0	1,601	871	435,500.0	1,461	1,077	107,700.0
8	Дундговь	49,200.0	1,136	320	160,000.0	917	844	84,400.0
9	Завхан	80,600.0	1,498	783	391,500.0	1,580	1,343	134,300.0
10	Өвөрхангай	114,900.0	2,153	855	427,500.0	2,007	1,934	193,400.0
11	Өмнөговь	46,500.0	1,068	515	257,500.0	683	738	73,800.0
12	Сүхбаатар	55,600.0	1,163	564	282,000.0	860	770	77,000.0
13	Сэлэнгэ	100,100.0	971	1,002	501,000.0	1,351	1,396	139,600.0
14	Төв	86,400.0	1,544	836	418,000.0	1,479	1,251	125,100.0
15	Увс	80,500.0	1,244	668	334,000.0	1,918	1,745	174,500.0
16	Ховд	88,500.0	1,297	627	313,500.0	1,856	1,739	173,900.0
17	Хөвсгөл	122,100.0	2,221	1,287	643,500.0	2,295	2,240	224,000.0
18	Хэнтий	71,000.0	1,447	652	326,000.0	1,326	1,152	115,200.0
19	Дархан-Уул	87,500.0	1,851	722	361,000.0	1,638	1,250	125,000.0
20	Орхон	79,400.0	2,243	1,523	761,500.0	1,397	1,054	105,400.0
21	Говьсүмбэр	12,300.0	343	204	102,000.0	268	220	22,000.0
22	Налайх	27,300.0	707	321	160,500.0	691	491	49,100.0
23	Багануур	25,700.0	440	227	113,500.0	671	401	40,100.0
24	СБД	123,100.0	2,023	857	428,500.0	2,325	1,725	172,500.0
25	ЧД	132,900.0	2,084	797	398,500.0	2,596	1,496	149,600.0
26	БЗД	211,600.0	4,444	2,015	1,007,500.0	3,708	3,108	310,800.0
27	ХУД	90,900.0	1,250	682	341,000.0	2,200	1,490	149,000.0
28	СХД	211,100.0	2,837	1,212	606,000.0	3,964	3,364	336,400.0
29	БГД	160,800.0	2,570	1,319	659,500.0	2,655	2,030	203,000.0
30	Багахангай	3,800.0	87	83	41,500.0	95	73	7,300.0
31	ИБМУТ		533		-			-
	Нийт	2,587,700.0	46,957	23,628	11,814,000.0	48,805	41,110	4,111,00.0

Хавсралт-2

Тэтгэвэр, тэгэмж, хөнгөлөлт, мөнгөн тусламж олгож буй байдал /2007 оны эхний хагас жилийн байдлаар/

№	Нийгмийн халамжийн багц хуулиудын заалт	Олгох хэмжээ мян.төг	Хамарсан хүний тоо	Олгосон дүн /сая.төг/	Шийдвэрлэж буй байдал
Халамжийн тэтгэвэр					
1	Тэжээн тэтгэх, хүүхэд, төрөл садангүй нэн ядуу амьдралтай 60, 55 ба дээш эр, эм	26.5	2,517	410.3	ЭХМК халамжийн тэтгэвэр авах эсхийг шийдвэрлэнэ.
2	Хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан тахир дутуу хүн	26.5	15,342	2,323.1	
3	16 насанд хүрсэн төрөлхийн тахир дутуу болон 16 насанд хүрээгүй байхдаа ТД болсон хүн	26.5	13,785	2,021.9	
4	Тэжээгч нь нас барсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд	26.5	8,880	1,387.5	
5	Бүрэн хараагүй, хэлгүй, дүлий болон одой хүн	26.5	1,899	279.9	
6	Нэн ядуу амьдралтай, өрх толгойлсон, 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 45-50 нас хүрсэн эх, эцэг	26.5	287	43.9	
7	Тэтгэвэр нь зогсоогдсон эмзэг бүлгийн иргэдэд 1 жилийн тэтгэврийн хэмжээтэй мөн/тус	26.5	1,967	564.6	
Дүн			44,677	7,031.4	
Халамжийн тэтгэмж					
1	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	20.0	62,889	5,473.4	АДОТБус зөвлөл шийдвэрлэнэ. Аргачлалаар тогтооно.
Үүнээс:	Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж	20.0	54,603	4,832.6	
	Ахмад настныг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмж	20.0	3,104	227.7	
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй хүнд олгох НМТ	20.0	5,182	413.1	
2	Хүүхэд асарсны тэтгэмж	12.4	22,331	1,389.5	
Үүнээс:	Нэг хүүхдийн		22,319	1,388.3	
	Хоёр хүүхдийн		12	1.2	
3	Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч, өсгөсний тэтгэмж	49.5	409	35.3	
Дүн			85,629	6,898.2	
Нийгмийн халамжийн үйлчилгээ/ ОНОТХҮйлчилгээ/					
1	Амьдралын итгэл үнэмшил, хөд-ийн дадал олгох, авьяас дэмжих зорилгоор зөвлөгөө, сургалт		1,077	14.8	Хэлтсүүд зохион байгуулна.
2	Зохион байгуулалттай хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох чиглэлээр зуучлах		337	49.9	
3	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах		647	37.9	
4	Түр байрлуулан асрамжлах		2,083	54.9	
5	Гэрийн халамж, асрамжийн үйлчилгээнд хамруулах		2,241	129.8	
Дүн			6,385	287.3	
Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулиар					
Үүнээс: Ядуу, нэн ядуу ахмад настанд үзүүлсэн үйлчилгээ					
1	Нэн ядуу амьдралтай ахмад настны орон сууцны хөлс төлөх, түлээ, нүүрс худалдан авахад нь	50.0	1,821	108.1	АДОТБус зөвлөл шийдвэрлэнэ. Хэлтсүүдээр дамжуулан олгоно.
2	Ахмадын зориулалттай рашаан сувилалд амрах эрхийн бичгийг хөнгөлөлттэй үнээр олгох		6,584	101.0	
3	Ортопедийн хэрэгслийн дотоодод хийлгэх 1 удаагийн зардал		23,610	571.3	
4	Нэн ядуу амьдралтай түүнчлэн хүндэт донор ахмад настны рашаан сувилалын нэг талын 50%		788	50.3	
5	НД-с оршуулгын тэтгэмж эрх авах үүсээгүй, нэн ядуу, ганц бие ахмад настны оршуулын тэт		43	4.4	
6	Ахмад настанд Билгийн улирлаар үзүүлсэн хүндэтгэл	5.0	32,477	202.5	
Дүн			65,323	1,037.6	
Алдар цолтон ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт					
1	Түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт	100.0	793	55.1	Амьжиргааны түвшин харгалзахгүй тул хуулиар бичиг баримтаа бүрдүүлнэ
2	Улирал, жилд олгодог нэг удаагийн мөнгөн тусламж	50-100	2,737	248.5	
3	Рашаан сувилалд явах унааны ирэх, буцахын зардал, зар бичгийн үнийн хөнгөлөлт		102	6.8	
4	Нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд ирэх, буцах унааны нэг удаагийн зардал		33	4.7	
5	Бусад нэмэлт хөнгөлөлт		40	0.2	
Дүн			3,705	315.3	
Ахмад насанд үзүүлэх нийт хөнгөлөлт тусламжийн дүн			69,028	1,352.9	
ХБИ-ний нийгмийн хамгааллын тухай хуулиар					
1	ХЧ-аа бүрэн алдсан тахир дутуу гишүүнтэй, нэн ядуу амьдралтай ХБ иргэнд түлээ, нүүрс авах	50.0	1,596	97.7	Амьжиргааны түвшин харгалзахгүй тул хуулиар бичиг баримтаа бүрдүүлнэ
2	18 хүртэлх насны ХБ-тэй хүүхдэд хийлгэсэн протезийг эхний удаа 100%, дараа 50% хөнгөлөлт		332	30.0	
3	НД сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй ХБ-ий дотоодод хийлгэсэн протезийг эхний удаа 100 хувь, дараагийн удаа 50 хувь хөнгөлөх		563	78.4	
4	Ядуу амьдралтай өрхийн 18 хүртэлх насны ХБ-тэй хүүхэд, НД-аас эрх үүсээгүй, ядуу амьдралтай ХБ-ий дотоодод хийлгэсэн ортопед, тэргэнцрийг 1 удаа олгох		2,847	154.7	
5	Харах, сонсох, чрих боломж нь хяргаарлагдмал сурагчийн тусгай сургуульд ирж очих унааны зардлыг жилд 1 удаа хөнгөлөх		358	17.9	
6	Нэн ядуу амьдралтай өрхийн ХЧ-аа алдсан иргэний дотоодын рашаан сувилалын эрхийн бичгийн үнийг 50 хувь хөнгөлөх		696	23.1	
7	Нэн ядуу амдралтай өрхийн ХЧ-аа бүрэн алдсан иргэний 4 хүртэлхи насны хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлыг хөнгөлөх		2,446	47.9	
8	Ядуу амьдралтай ХЧ-тай гишүүнгүй насанд хүрсэн бүрэн хараагүй иргэнтэй өрхийн телефон утасны төлбөрийг хөнгөлөх	10.0	133	13.1	
9	Уурхайчдын нөхөн олговор		1,341	187.2	
Дүн			10,312	650.0	
Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд эх гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулиар					
1	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	3.0	928,145	16,127.4	Амьжиргааны түвшин харгалзахгүй тул бичиг баримтаа бүрдүүлсэн хүн бүрт өгнө.
2	Шинэ гэр бүлд олгосон тусламж	500.0	11,682	5,841.0	
3	Шинэ төрсөн хүүхдэд олгосон тусламж	100.0	25,618	2,561.8	
4	Алдарт эхийн одонгийн тусламж 1-р одон	100.0	32,447	3,240.9	
5	Алдарт эхийн одонгийн тусламж 2-р одон	50.0	87,033	4,577.3	
Дүн			1,084,925	32,348.4	
НИЙТ ДҮН			1300956	48568.2	

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2006 оны
төсөвт зардлын гүйцэтгэл**

Зардлын зүйл	2005 оны гүйцэтгэл	2006 оны		Хэтрэлт, хэмнэлт /+:-/
		төсөв	гүйцэтгэл	
Цалин	67,268.8	92,834.8	92,833.8	(1.0)
Шимтгэл	17,759.0	25,749.7	25,290.9	(458.8)
Бичиг хэрэг	7,856.4	7,100.0	7,077.7	(22.3)
Гэрэл цахилгаан	1,851.0	3,297.3	3,297.3	-
Түлш халаалт	9,670.0	8,825.6	5,857.9	(2,967.7)
Тээвэр /шатахуун/	8,830.8	15,319.4	15,261.6	(57.8)
Шуудан холбоо	10,687.9	11,300.0	11,225.6	(74.4)
Цэвэр бохир ус	3,421.0	3,675.6	3,305.4	(370.2)
Дотоод албан томилолт	8,108.2	11,276.6	11,268.3	(8.3)
Ном хэвлэлийн зардал	1,680.4	1,900.0	1,886.2	(13.8)
Аж ахуйн материал авах	8,928.1	2,500.0	2,489.0	(11.0)
Нормын хувцас зөөлөн эдлэл	88.8	300.0	279.0	(21.0)
Маягтын зардал	4,641.5	6,000.0	5,994.2	(5.8)
Урсгал зардал	1,701.2	1,000.0	993.3	(6.7)
Төлбөр хураамж /бусад/	18,594.1	13,500.0	13,307.5	(192.5)
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	2,940.9			-
Төрийн өмнөөс үзүүлэх үйлчилгээ		5,374.6	5,353.8	(20.8)
Дүн	174,028.1	209,953.6	205,721.5	(4,232.1)

ХХҮГ-аас 2006, 2007 онд буцалтгүй тусламж, нийгмийн асуудал шийдвэрлэхээр олгосон мөнгөний жагсаалт

/сая.төг/

Д.д	Хүний нэр	Албан тушаал	Олгосон	
			2006	2007
1	Д.Баярсайхан	ХХҮГ-ын дарга	7.5	10.0
2	Б.Мөнхцэцэг	ХХҮГ-ын дэд дарга	8.0	6.0
3	Ж.Цогтбаатар	ХХҮГ-ын дэд дарга	8.0	6.0
4	Г.Ганбат	ХХҮГ-ын хэлтсийн дарга	7.5	7.5
5	Ц.Алтанчимэг	ХХҮГ-ын хэлтсийн дарга	8.0	6.0
6	Д.Батнасан	ХХҮГ-ын нягтлан бодогч	2.0	3.5
7	Д.Чойжилсүрэн	ХХҮГ-ын ахлах мэргэжилтэн		8.0
8	Л.Зандаамаа	ХХҮГ-ын нярав	2.0	3.0
9	Д.Хишигням	ХХҮГ-ын мэргэжилтэн	5.0	3.0
10	Б.Одонхүү	ХХҮГ-ын мэргэжилтэн	4.0	4.0
11	А.Сүхбат	ХХҮГ-ын тасгийн дарга	5.0	2.0
12	С.Чулуунцэцэг	ХХҮГ-ын мэргэжилтэн	4.0	2.0
13	Б.Дунгаамаа	ХХҮГ-ын мэргэжилтэн		6.0
14	Д.Мөнхтогтох	ХХҮГ-ын мэргэжилтэн	5.0	1.0
15	Д.Ганчимэг	ХХҮГ-ын ахлах мэргэжилтэн		2.0
16	У.Сосорбурам	ХХҮГ-ын мэргэжилтэн		5.0
17	Ц.Батсүрэн	ХХҮГ-ын мэргэжилтэн	3.0	2.0
18	Ц.Даваасүрэн	ХХҮГ-ын мэргэжилтэн		5.0
19	Т.Эрдэнэбилэг	ХХҮГ-ын мэргэжилтэн		5.0
20	Д.Дэлгэрдүүрэн	ХХҮГ-ын мэргэжилтэн		4.0
21	Т.Лхагвасүрэн	ХХҮГ-ын мэргэжилтэн		4.0
22	Ч.Эрдэнэбулган	ХХҮГ-ын мэргэжилтэн		4.0
23	С.Отгондэлгэр	ХХҮГ-ын мэргэжилтэн	3.0	1.0
24	Б.Амаржаргал	ХХҮГ-ын мэргэжилтэн	3.0	1.0
25	Н.Буяннэмэх	ХХҮГ-ын мэргэжилтэн		3.0
26	Д.Батжаргал	ХХҮГ-ын ахлах мэргэжилтэн		3.0
27	Л.Батцэцэг	ХХҮГ-ын мэргэжилтэн		3.0
28	В.Дэлгэрзаяа	ХХҮГ-ын мэргэжилтэн		3.0
29	Ө.Цогцолмаа	ХХҮГ-ын мэргэжилтэн		3.0
30	Ч.Номинтуяа	ХХҮГ-ын мэргэжилтэн		3.0
31	Ц.Гансүх	ХХҮГ-ын мэргэжилтэн		3.0
32	Б.Байгалмаа	ХХҮГ-ын мэргэжилтэн		3.0
33	Ц.Хатанхангай	ХХҮГ-ын мэргэжилтэн		1.0
34	Ц.Дүгэрмаа	ХХҮГ-ын даргын туслах		1.0
35	Ж.Баасансүрэн	ХХҮГ-ын жолооч	4.0	
36	Б.Өлзийдэлгэр	ХХҮГ-ын мэргэжилтэн	3.0	
37	С.Үржинбадам	НХХЯ-ны ХЗЗБЗГ-ын мэргэжилтэн		7.0
38	Б.Алимаа	НХХЯ-ны ХЗЗБЗГ-ын ахлах мэргэжилтэн		7.0
39	Д.Норжмаа	НХХЯ-ны МХШҮГ-ын мэргэжилтэн		7.0
40	Б.Батсүх	НХХЯ-ны НХБЗГ-ын мэргэжилтэн		7.0
41	Б.Пүрэвсүрэн	НХХЯ-ны ХАХБЗГ-ын мэргэжилтэн		7.0
42	Б.Алтанжаргал	НХХЯ-ны Хуулийн зөвлөх		7.0
43	С.Наранцацрал	НХХЯ-ны МХШҮГ-ын мэргэжилтэн		7.0
	Дүн		82.0	176.0

**2005 оноос 2007 оны эхний 8 сар хүртэл Халамжийн зөвлөлийн
хурлын шийдвэрээр гэр олгосон байдал /иж бүрдлээр/**

Д.д	Аймаг, дүүрэг дэх ХХҮХ-үүд	2005	2006	2007 оны эхний 8 сарын байдлаар	Дүн
1	Архангай	12	70	12	94
2	Баянхонгор		11		11
3	Баян-Өлгий	2			2
4	Булган		4	1	5
5	Говь-Алтай	2	7	3	12
6	Дорноговь	3	1	35	39
7	Дорнод	8	20		28
8	Дундговь		1	3	4
9	Завхан	1	30	2	33
10	Өвөрхангай	6	71	37	114
11	Өмнөговь	20	16	1	37
12	Сүхбаатар		15		15
13	Сэлэнгэ	6	1	1	8
14	Төв	3	5	10	18
15	Увс	5	3		8
16	Ховд	2			2
17	Хөвсгөл	1	50		51
18	Хэнтий		8	1	9
19	Дархан-Уул	2	1	2	5
20	Орхон		1	8	9
21	Говьсүмбэр		3	1	4
22	Налайх	1	1		2
23	Багануур		1	26	27
24	Сүхбаатар дүүрэг	15	20	26	61
25	Чингэлтэй дүүрэг	8	5	11	24
26	Баянзүрх	11	27	34	72
27	Хан-Уул	5	6	2	13
28	СХДүүрэг	13	34	19	66
29	Баянгол	30	43	16	89
30	Багахангай		7		7
	Дүн	156	462	251	869

ТАХИР ДУТУУ БУЮУ ОДОЙ ХҮН АЖИЛЛУУЛААГҮЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТӨЛБӨРИЙН 2006 ОНЫ ТАЙЛАН /өссөн дүнгээр/

Д-д	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлстүүд	Тахир дутуу буюу одой иргэдийг ажиллуулах аж ахуйн нэгж, байгууллагууд	Төлбөрийн эхний үлдэгдэл	Ажил албан тушаалын тоо	Ажиллуулбал зохих тахир дутуу буюу одой хүний тоо	Үүнээс: ажиллуулж байгаа	Тайлант хугацаанд дансанд төлбөл зохих төлбөрийн хэмжээ /мян.төг/	Төлсөн /мян.төг/	Төлөгдөөгүй /мян.төг/
1	Архангай	11	2,883.0	1118	29	31	159.0	0	3,042.0
2	Баян-Өлгий	11	7,991.0	791	24	24	-	486	7,505.0
3	Баянхонгор	14	19,548.0	1515	43	31	689.0	0	20,237.0
4	Булган	15	18,013.0	1311	37	26	689.0	0	18,702.0
5	Говь-Алтай	14	17,093.0	1389	37	28	742.0	0	17,835.0
6	Дорноговь	19	85,709.0	3389	89	22	3,710.0	0	89,419.0
7	Дорнод	20	22,770.0	2885	83	51	1,325.0	0	24,095.0
8	Дундговь	8	7,638.0	668	23	18	265.0	0	7,903.0
9	Завхан	11	-	1011	30	45	-	0	-
10	Өвөрхангай	18	33,605.0	1701	45	49	1,166.0	0	34,771.0
11	Өмнөговь	10	424.0	1341	33	33	212.0	636	-
12	Сүхбаатар	12	14,883.0	1476	32	24	477.0	0	15,360.0
13	Сэлэнгэ	38	82,485.0	139	139	84	2,862.0	0	85,347.0
14	Төв	29	53,420.0	3703	104	70	1,600.0	0	55,020.0
15	Увс	10	7,586.0	1011	29	19	530.0	0	8,116.0
16	Ховд	13	11,296.0	1489	42	35	530.0	0	11,826.0
17	Хөвсгөл	31	84,013.0	2759	74	20	2,915.0	0	86,928.0
18	Хэнтий	3	16,803.0	406	11	0	583.0	0	17,386.0
19	Дархан-Уул	36	13,250.0	5837	157	132	2,014.0	0	15,264.0
20	Орхон	26	-	10257	300	163	141.0	0	-
21	Говьсүмбэр	12	15,713.0	1139	29	16	795.0	0	16,508.0
22	Хан-Уул	31	226,575.0	9033	261	108	8,109.0	0	234,684.0
23	Багануур	15	11,777.0	2776	81	82	1,099.0	0	12,876.0
24	Баянзүрх	60	85,484.0	8197	240	197	3,021.0	0	88,505.0
25	Налайх	14	5,630.0	1758	52	57	212.0	0	5,842.0
26	Баянгол	147	492,170.0	0	0	0	27,719.0	0	519,889.0
27	Сүхбаатар	63	257,850.0	7297	214	44	9,010.0	0	266,860.0
28	Чингэлтэй	42	25,155.0	6060	156	111	3,074.0	0	28,229.0
29	Баганхангай	0	-	0	0	0	-	0	-
30	Сонгинохайрхан	37	52,800.0	6328	179	124	3,286.0	0	56,086.0
	Нийт	770	1,672,564.0	86645.0	2573.0	1644.0	76,934.0	1122	1,748,235.0



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2007 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасны дагуу аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийг хавсралтаар баталсугай.

Гурав. Аудитын тайланг Улсын Их Хурал, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2008 оны 5 дугаар 1-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Баярсайханд зөвлөсүгэй.

Тав. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний Аудитын газрын хоёрдугаар газрын захирал О.Мэндбаярт үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

L. Javзмаа

Л.ЖАВЗМАА

tushaal
075253

Монгол Улсын Ерөнхий аудиторовн
2007 оны 11 сарын 28-ний өдрийн
88 тоот тушаалын хавсралт

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАРТ
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ТӨЛБӨР, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

(мянган төгрөгөөр)

Д.д	Төлбөр хариуцагчийн		Төлбөр, зөрчлийн товч утга	Төлбөрийн дүн	Зөрчлийн дүн
	нэр	албан тушаал			
1	Г.Ганбат	Санхүү, хяналтын хэлтсийн дарга	"Сорос компьютер" ХХК-аас нийлүүлсэн энгийн дэлгэцтэй DELL маркийн 4 ш компьютерийг бусдад хандивласан	4212,0	
2	Д.Баярсайхан	ХХҮГ-ын дарга	Эрхий бүхий байгууллагын зөвшөөрөл, шийдвэргүйгээр энгийн дэлгэцтэй DELL маркийн 3 ширхэг компьютер, 3 ширхэг принтерийг УМХГ-т хандивласан	-	3864,3
3	Д.Баярсайхан	ХХҮГ-ын дарга	Иргэн н.Мөнхнасангийн буруутай ажиллагаанаас болж УБЗ-06-28 улсын дугаартай автомашины засвар үйлчилгээний зардлыг ХЭДС-ийн хөрөнгөөс гаргасан	-	3865,2
4	Д.Баярсайхан	ХХҮГ-ын дарга	"Батуудын-Эхлэл" ХХК-ийн авсан зээл, зээлийн хүүгийн төлбөрийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай сангаас төлсөн	-	4570,0
	Дүн			4212,0	12299,5